БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

2026 IX

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



www.1212.mn

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

САРЫН ТАНИЛЦУУЛГА

2026 оны 9 дүгээр сар

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2022-2026 он	7
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	7
I.	Нийгмийн даатгал, халамж	8
II.	Эрүүл мэнд	14
III.	Гэмт хэрэг	17
IV.	Төсөв	25
V.	Хэрэглээний үнэ	28
VI.	Аж үйлдвэр	33
VII.	Цаг уур, агаарын чанар, аюулт үзэгдэл, осол	38

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII … г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI … г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

-	гүйцэтгэл байхгүй
*	урьдчилсан гүйцэтгэл
**	дахин их
1/X**	дахин бага
0.0	маш бага тоо
|	харьцуулагдахгүй
0.0=	тэнцүү/ өөрчлөлтгүй

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/



V. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000
сая	$=10^6$
тэрум	$=10^9$
их аяд	$=10^{12}$
мян	мянга
%	хувь
мм	миллиметр
см	сантиметр
дм	дециметр
м	метр
км	километр
$м^2$	метр квадрат
$дм^2$	дециметр квадрат
$км^2$	километр квадрат
$м^3$	метр куб
га	гектар
мл	миллилитр
л	литр
г	грамм
кг	килограмм
цн	центнер
т	тонн
Вт	ватт
кВт.ц	киловатт цаг
кал	калори
ккал	килокалори
Гкал	гигакалори($=10^9$ калори)
с	секунд
мин	минут
$мкг/м^3$	микрограмм метр куб
м/с	метр секунд
ш	ширхэг
х.д.х	хэвлэлийн даралтат хуудас

МЭДЭЭЛЭЛ

МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ

ХҮСНЭГТ 1. БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт		Хэмжих нэгж	2022 I-IX	2023 I-IX	2024 I-IX	2025 I-IX	2026 I-IX
Шинээр төрсөн хүүхэд		Хүн	2 947 ↓18.6	2 907 ↓1.4	2 411 ↓17.1	2 354 ↓2.4	2 296 ↓2.5
Халдварт өвчнөөр өвчлөгчсөд		Хүн	24 003 ↓10.6	1 707 ↓92.9	1 648 ↓3.5	3 689 ↑123.8	2 023 ↓45.2
Бүртгэгдсэн гэмт хэрэг		Тоо	3 734 ↑1.11	3 415 ↓8.5	3 640 ↑6.6	4 273 ↑17.4	5 344 ↑25.1
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)		Хувь	-0.3 ↓0.7	-0.1 ↓66.7	0.1 ↓2.0**	0.1 =0.0	0.4 ↑3.0**
Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж)	Доллар (АНУ)	Төгрөг	3 257 ↑14.3	3 466 ↑6.4	3 381 ↓2.5	3 594 ↑6.3	3 595 =0.0
	Юань (БНХАУ)	Төгрөг	464 ↑5.2	475 ↑2.4	478 ↓0.6	504 ↑5.4	536 ↑6.3
	Рубль (ОХУ)	Төгрөг	54 ↑38.5	36 ↓33.3	37 ↑2.8	44 ↑18.9	42 ↓4.5
Дүүргийн төсвийн орлого		Тэрбум төгрөг	85.5 ↑6.6	132.3 ↑54.7	188.6 ↑42.6	207.7 ↑10.1	246.3 ↑18.6
Дүүргийн төсвийн зарлага		Тэрбум төгрөг	78.4 ↑16.7	121.4 ↑54.8	183.8 ↑51.4	222.7 ↑21.2	237.5 ↑6.6
Агаарын дундаж температур		°C	11.8	17.9	10.6	10.7	11.3

ХҮСНЭГТ 2. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 I-IX					2026 I-IX				
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	357	БГД	8 797	НД	59	356	БГД	8 637	НД	59
			ЧД	1 490	БНД	47		ЧД	1 446	БНД	47
			СБД	688	БХД	32		СБД	677	БХД	30
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	15	БХД	21	СБД	12	13	БНД	20	ХУД	8
			БНД	18	ЧД	12		НД	17	БГД	6
			СБД	12	ХУД	8		ЧД	14	БХД	-
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	183	БЗД	204	СХД	129	125	БНД	208	ХУД	76
			БНД	170	НД	65		БЗД	124	НД	72
			ХУД	155	БХД	56		СБД	102	БХД	14
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	70	БЗД	108	НД	81	90	ХУД	401	НД	78
			ХУД	103	БХД	74		СБД	367	БНД	73
			СБД	103	БНД	22		БГД	303	БХД	23
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	241	СБД	395	БНД	142	258	СБД	431	НД	164
			ЧД	344	НД	83		ЧД	329	БНД	152
			ХУД	259	БХД	80		БГД	317	БХД	76

НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгалын орлого өмнөх оны мөн үеэс 15.8 хувиар, нийгмийн даатгалын зарлага 15.2 хувиар тус тус өссөн байна.


2026 оны 9 дүгээр сарын байдлаар нийгмийн даатгалын 5 төрлийн санд нийт 461.6 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 63.1 (15.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн 9 дүгээр сард

Үзүүлэлт	2025 IX	2026 IX	2026 IX / 2025 IX
	сая төгрөг		хувь
Нийт орлого	398 469.3	461 564.3	15.8
Тэтгэврийн даатгалын сангийн	330 599.7	382 936.0	15.8
Тэтгэмжийн даатгалын сангийн	35 234.3	41 025.7	16.4
ҮОМШӨ[1]-ний даатгалын сангийн	20 187.8	23 308.0	15.5
Ажилгүйдлийн даатгалын сангийн	12 447.5	14 294.6	14.8
Эрүүл мэндийн даатгалын сангийн	-	-	-
Нийт зарлага	352 533.6	403 911.0	14.6
Тэтгэврийн даатгалын сангийн	314 404.9	357 200.0	13.6
Тэтгэмжийн даатгалын сангийн	19 721.6	27 059.9	37.2
ҮОМШӨ[1]-ний даатгалын сангийн	2 013.2	2 134.6	6.0
Ажилгүйдлийн даатгалын сангийн	16 393.9	17 516.5	6.8


[1] -Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

ЗУРАГ 1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, дүнд эзлэх хувиар, 2026 оны 9 дүгээр сард



Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 83.0 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 5.0 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 8.9 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 3.1 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

ЗУРАГ 2. **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, дүнд эзлэх хувиар, 2026 оны 9 дүгээр сард**




Нийгмийн даатгалын сангаас 2026 оны 9 дүгээр сарын байдлаар даатгуулагч иргэдэд 403.9 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд зарцуулжээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 51.4 (14.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт зардлын 88.5 хувийг тэтгэврийн, 0.5 хувийг ҮОМШӨ-ний, 6.7 хувийг тэтгэмжийн, 4.3 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

ХҮСНЭГТ 4. **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 9 дүгээр сард**

Үзүүлэлт	Тэтгэвэр, тэтгэмж авагчид			Олгосон тэтгэвэр, тэтгэмж		
	2025 IX	2026 IX	2026 IX / 2025 IX	2025 IX	2026 IX	2026 IX / 2025 IX
	тоо		хувь	сая төгрөг		хувь
Сангийн нийт зарлага	**52 434**	**52 164**	**-0.5**	**352 533.6**	**403 911.0**	**14.6**
Тэтгэврийн даатгалын сан	**35 420**	**36 606**	**3.3**	314 404.9	**357 200.0**	**13.6**
Өндөр насны	28 464	29 622	4.1	257 093.2	292 625.4	13.8
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэвэр	3 833	3 753	-2.1	22 888.4	25 352.4	10.8
Тэжээгчээ алдсаны	1 201	1 255	4.5	7 175.6	8 581.8	19.6
Цэргийн тэтгэвэр	1 922	1 976	2.8	27 229.0	30 621.3	12.5
Бусад зардал	-	-	-	18.7	19.2	2.7
Тэтгэмжийн даатгалын сан	**13 293**	**11 757**	**-11.6**	**19 721.7**	**27 059.9**	**37.2**
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	9 557	8 102	-15.2	4 585.4	4 310.5	-6.0
Жирэмсэн, амаржсаны тэтгэмж	3 083	2 964	-3.9	13 697.3	16 774.6	22.5
Оршуулгын тэтгэмж	653	691	5.8	1 306.0	2 074.5	58.8
Ажилгүйдлийн тэтгэмж	-	-	-	-	3 714.8	-
Бусад зардал	-	-	-	133.0	185.6	39.5
ҮОМШӨ[1]-ний даатгалын сан	**306**	**328**	**7.2**	**2 013.1**	**2 134.6**	**6.0**
Тахир дутуугийн тэтгэмж	145	138	-4.8	1 416.0	1 455.5	2.8
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	25	25	0.0	265.2	283.3	6.8
Тэтгэмж, төлбөр	136	152	11.8	257.4	313.3	21.7
ҮОМШӨ[1]-ний сувилал	-	13	-	4.9	15.3	2.1**
Бусад зардал	-	-	-	69.6	67.2	-3.4
Ажилгүйдлийн даатгалын сан	**3 415**	**3 473**	**1.7**	**16 393.9**	**17 516.5**	**6.8**
Ажилгүйдлийн тэтгэмж	3 415	3 473	1.7	16 393.9	17 516.5	6.8

2026 оны 9 дүгээр сарын байдлаар нийгмийн даатгалын сангаас нийт 52164 иргэнд 403911.0 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгогдсоны 36606 иргэнд 357200.0 сая төгрөгийг тэтгэврийн даатгалын сангаас, 11757 иргэнд 27059.9 сая төгрөгийг тэтгэмжийн даатгалын сангаас, 3473 иргэнд 17516.5 сая төгрөгийг ажилгүйдлийн даатгалын сангаас, 328 иргэнд 2134.6 сая төгрөгийг үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас тус тус зарцуулсан байна.

ЗУРАГ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо, жил бүрийн 9 дүгээр сард



2026 оны 9 дүгээр сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 36606 иргэнд 357.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгогдсоны 80.9 хувийг өндөр настны, 10.3 хувийг хөдөлмөрийн чадвар түр алдсаны, 3.4 хувийг тэжээгчээ алдсаны, 5.4 хувийг цэргийн тэтгэвэр тус тус эзэлж байна. Тэтгэвэр авагчдийн 80.8 хувийг өндөр настны тэтгэвэр эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1158.0 (4.1%) иргэнээр, 35.5 (13.8%) тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

НИЙГМИЙН ХАЛАМЖ

Нийгмийн халамжийн зарлага өмнөх оны мөн үеэс 5.1 хувиар өссөн байна.

Нийгмийн халамж нь орлого багатай, хүүхэд, өндөр настан зэрэг зорилтот бүлэгт чиглэсэн арга хэрэгсэл юм. Нийгмийн халамжийн сангаас 2026 оны 9 дүгээр сарын байдлаар нийт 1091.4 мянган иргэнд 131623.9 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж олгогдож, өнгөрсөн оны мөн үеэс 3295.0 (0.3%) иргэнээр буурсан бол 6480.0 (5.2%) сая төгрөгөөр өссөн байна. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 86346.3 (65.6%) сая төгрөгийг хүүхдийн мөнгөн тэтгэмж, 11743.5 (8.9%) сая төгрөгийг нийгмийн халамжийн тэтгэвэрт, 13852.3 (10.5%) сая төгрөгийг асаргааны тэтгэмж, 4217.6 (3.2%) сая төгрөгийг эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж, үлдсэн 15464.2 (11.8%) сая төгрөгийг онцгой тохиолдолын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, алдар цолтой ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламж, ахмад настны тэтгэмж хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж болон бусад тусламж тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 9 дүгээр сард

Үзүүлэлт	2025 IX		2026 IX		2026 IX / 2025 IX
	Хүн	Гүйцэтгэл	Хүн	Гүйцэтгэл	
	тоо	сая төгрөг	тоо	сая төгрөг	хувь
Нийт олгогдсон тэтгэвэр, тэтгэмж	**1 094 679**	**125 143.9**	**1 091 384**	**131 623.9**	**5.2**
Тэтгэвэр	25 045	9 805.3	26 063	11 743.5	19.8
Асаргааны тэтгэмж	41 258	11 914.0	42 177	13 852.3	16.3
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	78 698	4 458.3	72 583	4 217.6	-5.4
Алдарт эхийн одонгийн тусламж	12 962	3 019.5	13 441	3 117.1	3.2
Алдар цолтой ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламж	120	53.3	124	823.3	14.4**
Хүүхдийн мөнгө	865 816	86 581.6	863 463	86 346.3	-0.3
Насны хишиг	30 108	2 418.4	32 164	2 581.0	6.7
Онцгой тохиолдолын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	18	21.6	25	30.0	38.9
Ахмад настны тэтгэмж, хөнгөлөлт	-	-	-	-	-
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж	-	-	-	-	-
Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	20 193	4 306.3	23 164	6 123.8	42.2
Бусад	20 461	2 565.4	18 180	2 789.0	8.7

Энэ оны 9 дүгээр сарын байдлаар 32164 ахмадад 2581.0 сая төгрөгийн насны хишгийг зарцуулагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2056 (6.8%) хүн, 162.6 (6.7%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 6. АХМАД НАСТНЫ ТЭТГЭМЖ, ХӨНГӨЛӨЛТ, төрлөөр, жил бүрийн 9 дүгээр сард

Үзүүлэлт	2025 IX		2026 IX		2026 IX / 2025 IX
	Хүн	Гүйцэтгэл	Хүн	Гүйцэтгэл	
	тоо	мянган төгрөг	тоо	мянган төгрөг	хувь
Бүгд	**10 287**	**2 234 812.5**	**9 350**	**2 292 738.0**	**2.6**
Оршуулгын тэтгэмж	25	50 000.0	14	41 000.0	-18.0
Амралт, сувилал	3 612	920 525.0	3 079	783 260.0	-14.9
Рашаан, сувилал	4 299	892 309.3	3 987	1 082 083.4	21.3
Протез	1 901	243 476.2	1 692	219 923.0	-9.7
Ортопед, тусгай хэрэгсэл	448	128 222.0	566	164 791.6	28.5
Ахмадын хүндэтгэл	-	-	-	-	-
Түлш болон орон сууцны үнийн хөнгөлөлт	2	280.0	12	1 680.0	5.0**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулан харвал хүний тоо 546 (15.2%), олгосон тэтгэмж 152.4 (59.9%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 7. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨНГӨЛӨЛТ, ТУСЛАМЖ, төрлөөр, жил бүрийн 9 дүгээр сард

Үзүүлэлт	2025 IX		2026 IX		2026 IX / 2025 IX
	Хүн	Гүйцэтгэл	Хүн	Гүйцэтгэл	
	тоо	мянган төгрөг	тоо	мянган төгрөг	хувь
Бүгд	**3 592**	**254 552.7**	**4 138**	**406 977.9**	**59.9**
Харилцаа, холбооны зардлын хөнгөлөлт	3 028	59 785.7	2 999	59 855.0	0.1
Оршуулгын тэтгэмж	30	60 000.0	17	51 000.0	-15.0
Цэцэрлэг сургуулийн унааны зардал	24	4 800.0	20	4 000.0	-16.7
Рашаан сувилал	176	52 861.0	165	75 577.2	43.0
Протез	90	14 325.0	133	25 750.0	79.8
Ортопед тусгай хэрэгсэл	205	54 381.0	763	185 055.7	2.4**
Түлш болон орон сууцны үнийн хөнгөлөлт	39	8 400.0	41	5 740.0	-31.7
Бусад	-	-	-	-	-

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөнгөлөлт, тусламж авсан нийт хүний дийлэнх буюу 72.5 хувийг харилцааны холбооны зардлын хөнгөлөлт авсан иргэд эзэлж байгаа боловч олгосон тэтгэмж нь 14.7 хувь байна. Харин ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлт, тусламж авсан иргэдийн мөнгөн дүн 45.5 буюу хамгийн их хувийг эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Нийгмийн халамж: Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Байнгын асаргаа шаардлагатай иргэн: Бусдын туслалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй, эсхүл оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүнийг хэлнэ.

Бүтэн өнчин хүүхэд: Эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх/эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг хэлнэ.

Өрх толгойлсон эх /эцэг/: Нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсхүл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эх /эцэг/-ийг хэлнэ.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ: Асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагаа хэлнэ.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ: Иргэн, аж ахуйн нэгж, төр болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ.

Эх үүсвэр:

Дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн сарын мэдээ

Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн сарын мэдээ

ЭРҮҮЛ МЭНД

2026 оны 9 сард 2 265 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 63 (2.7%) төрөлтөөр буурсан байна.


Дүүргийн хэмжээнд 2026 оны эхний 9 сард 2265 эх амаржиж, 2296 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 63 (2.7%), мэндэлсэн хүүхэд өмнөх оны мөн үеэс 58 (2.5%) хүүхдээр тус тус буурсан байна. Амьгүй төрөлтийн 8 тохиолдол бүртгэгджээ. Нийт амаржсан эхчүүдийн дунд гэртээ төрсөн тохиолдол бүртэгдээгүй байна.

ХҮСНЭГТ 8. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, жил бүрийн эхний 9 сард

Үзүүлэлт	2024 I-IX	2025 I-IX	2026 I-IX	Өөрчлөлт %
Амаржсан эхийн тоо	**2 382**	**2 328**	**2 265**	**-2.7**
Гэрийн төрөлт	1	3	-	-
Хяналтгүй төрөлт	4	6	9	50.0
Амьгүй төрөлт	5	4	8	100.0
Амьд төрсөн хүүхэд	2 411	2 354	2 296	-2.5
Эхийн эндэгдэл	-	1	-	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	25	21	13	-38.1
1-5 настай хүүхдийн эндэгдэл	4	3	5	66.7
Нас барсан хүн	713	720	728	1.1

2026 оны эхний 9 сард 0-1 хүртэл насандаа эндсэн 13 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 8 (38.1%)-аар буурсан байгаа бол 1-5 настай хүүхдийн эндэгдэл 8 бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 4 (100.0%)-аар өссөн байна. Дүүргийн хэмжээнд нас баралт 728 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 8 (1.1%) хүнээр өссөн байна.

ЗУРАГ 4. ХАЛДВАРТ ӨВЧИН, сараар



Дүүрэгт 2026 оны эхний 9 сарын байдлаар 2026 халдварт өвчин бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1666 (45.2%) тохиолдлоор буурсан байна. Цочмог халдварт өвчний 25.2 хувийг салхин цэцэг, 3.4 хувийг улаан эсэргэнэ, 35.1 хувийг энтервирүст цэврүүт фарингит, 7.1 хувийг улаан бурхан, 29.2 хувийг цусан суулга, ёлом, хепатит, сальмонеллёз зэрэг өвчин тус тус эзлээд байна.

ХҮСНЭГТ 9. ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эхний 9 сард

Төрөл	Хэмжих нэгж	2024 I-IX	2025 I-IX	2026 I-IX	Өөрчлөлт	
					тоо/нэгж хувь	хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн, бүгд	**тоо**	**1 645**	**3 689**	**2 023**	**-1 666**	**-45.2**
	10000 хүнд	**65.9**	**144.0**	**78.7**	**-65.3**	
Вируст хепатит	тоо	16	16	8	-8	-50.0
	10000 хүнд	0.3	0.0	0.0	-	
Цусан суулга	тоо	193	122	75	-47	-38.5
	10000 хүнд	7.8	4.8	2.9	-1.9	
Сальмонеллёз	тоо	48	63	51	-12	-19.0
	10000 хүнд	1.9	2.5	2.0	-0.5	
Халдварын гаралтай гастроэнтерит ба суулга өвчин	тоо	-	15	4	-11	-73.3
	10000 хүнд	-	0.6	0.2	-0.4	
Хоолны хордлого	тоо	35	57	26	-31	-54.4
	10000 хүнд	1.4	2.2	1.0	-1.2	
Энтервируст халдвар тодорхойгүй/B34.1/	тоо	-	150	81	-69	-46.0
	10000 хүнд	-	5.9	3.2	-2.7	
Салхинцэцэг	тоо	508	616	410	-206	-33.4
	10000 хүнд	20.3	24	15.9	-8.1	
Гахай хавдар	тоо	32	9	9	-	0.0
	10000 хүнд	1.3	0.4	0.4	-	
Улаан эсэргэнэ	тоо	61	67	55	-12	-17.9
	10000 хүнд	2.44	2.62	2.14	-0.48	
Ёлом	тоо	10	21	12	-9	-42.9
	10000 хүнд	0.4	0.8	0.5	-0.3	
Бруцеллёз	тоо	-	-	-	-	-
	10000 хүнд	-	-	-	-	
Менингококт халдвар	тоо	-	1	2	1	100
	10000 хүнд	-	0	0.1	0.1	
Энтервируст тууралттай цэврүүт фарингит	тоо	171	121	571	450	371.9
	10000 хүнд	6.8	4.7	22.2	17.5	
Эритема	тоо	1	237	37	-200	-84.4
	10000 хүнд	-	9.3	1.4	-7.9	
Улаан бурхан	тоо	-	1 563	116	-1 447	-92.6
	10000 хүнд	-	61	4.5	-56.5	
Спирохетээр сэдээгдсэн бусад халдвар/A69	тоо	-		1	1	-
	10000 хүнд	-		-	-	-
Хачигт рикеттсиоз	тоо	1	1	9	8	9.0**
	10000 хүнд	-	0	0.4	0.4	-
Бусад халдварт өвчин	тоо	-	160	160	-	0.0
	10000 хүнд	-	6.2	6.2	-	

Төрөл	Хэмжих нэгж	2024 I-IX	2025 I-IX	2026 I-IX	Өөрчлөлт	
					тоо/нэгж хувь	хувь
Хачгаар дамжих вируст энцефалит, тодорхойгүй A84.9	тоо			1	1	-
	10000 хүнд			0.0	-	-
Тэмбүү	тоо	268	188	180	-8	-4.3
	10000 хүнд	10.7	7.3	7.0	-0.3	
Гонококкт халдвар	тоо	105	99	47	-52	-52.5
	10000 хүнд	4.2	3.9	1.8	-2.1	
Трихомониаз	тоо	69	52	56	4	7.7
	10000 хүнд	2.8	2	2.2	0.2	-
Сүрьеэ	тоо	127	131	111	-20	-15.3
	10000 хүнд	5.1	5.1	4.3	-0.8	
ДОХ	тоо	-	-	-	-	-
	10000 хүнд	-	-	-	-	
Мөөгөнцөр	тоо	-	-	1	1	-
	10000 хүнд	-	-	-	-	

Өнгөрсөн оны мөн үеэс гоногоккт халдвар 52 (52.5%) тохиолдлоор буурсан эерэг үзүүлэлттэй байна. 10.0 мянган хүн тутмын 7.0 нь тэмбүү өвчнөөр өвчилж байна.

Баянгол дүүрэгт 2026 оны эхний 9 сард 1628 хүн цочмог халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 1591 (49.4%) хүнээр буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

Эх үүсвэр:
Дүүргийн Эрүүл мэндийн төвийн сарын мэдээ

ГЭМТ ХЭРЭГ

Баянгол дүүрэгт 5 344 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1071 (25.1%) хэргээр өссөн байна.


2026 оны 9 сард 5344 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1071 (25.1%) хэргээр өсөж, гэмт хэргийн илрүүлэлт 42.2 хувьтай байгаа нь 8.0 нэгж хувиар өссөн байна. Гэмт хэргийн улмаас 4977 иргэн хохирч, 90.7 сая төгрөгийн хохирол учруулснаас 36.5 сая (40.2%) төгрөгийг нөхөн төлүүлжээ. Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 43.2 хувийг залилан, 13.9 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 16.2 хувийг хулгайн, 3.2 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 1.2 хувийг хүний амьд явах эрхийн эсрэг, 1.9 хувийг дээрмийн, 1.2 хувийг хүчин, 0.3 хувийг хүнийг санаатай алах, 19.0 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 10. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн 9 дүгээр сард

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өөрчлөлт	
	2024 IX	2025 IX	2026 IX	Тоо	Хувь
Нийт гэмт хэрэг	**3 640**	**4 273**	**5 344**	**1 071**	**25.1**
Хүнийг санаатай алах	16	11	15	4	36.4
Хүний амьд явах эрхийн эсрэг	47	27	62	35	1.3**
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	671	709	742	33	4.7
Хүчиндэх	31	47	62	15	31.9
Хулгайлах	722	666	866	200	30.0
Дээрэмдэх	87	106	100	-6	-5.7
Залилан	1 331	1 909	2 311	402	21.1
Танхайрах	-	3	2	-1	-33.3
ХАБТХАЖЭ	134	146	171	25	17.1
Бусад гэмт хэрэг	601	649	1 013	364	56.1

Өнгөрсөн оны мөн үеэс дүүргийн нутаг дэвсгэрт гарсан гэмт хэрэг өссөн сөрөг үзүүлэлтэд хүнийг санаатай алах 4 (36.4%), хүний амьд явах эрхийн эсрэг 35 (129.6%), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 33 (4.7%), хүчин 15 (21.1%), хулгайлах 200 (30.0%), залилан 402 (21.1%), хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 25 (17.1%), бусад гэмт хэрэг 364 (56.1%) нэгжээр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Харин дээрэмдэх 6 (5.7%), танхайрах 1 (33.3%) нэгж нэгж хэргээр буурсан эерэг үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 5. **БҮРТГЭГДСЭН ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2026 оны 9 дүгээр сард**



Бүртгэгдсэн хулгайн гэмт хэргийн 714 (82.5%) нь иргэдийн өмчийн, 98 (11.3%) нь халаасны, 16 (1.8%) нь авто тээврийн хэрэгсэл, 38 (4.4%) нь бусад хулгайн гэмт хэрэг тус тус эзэлж байна. Харин өнгөрсөн оны мөн үеэс авто тээврийн хэрэгслийн хулгай хамгийн их буюу 48.4 хувь буурсан байна.

Монгол Улсын Эрүүгийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж ангилдаг болсон. 2026 оны 9 дүгээр сарын байдлаар бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 4978 (93.2%) нь хөнгөн хэрэг, 366 (6.8%) нь хүнд хэрэг байна.


ХҮСНЭГТ 11. **БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, хэлтсээр, 2026 оны 9 дүгээр сард**

Төрөл		Бүгд	Цагдаагийн I хэлтэс	Цагдаагийн II хэлтэс
		тоо		
Нийт гэмт хэрэг		**5 344**	**2 981**	**2 363**
Хэргийн ангилал	Хөнгөн	4 978	2 779	2 199
	Хүнд	366	202	164
Гэмт хэргийн төрөл	Хүнийг алах	15	9	6
	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	62	28	34
	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	742	375	367
	Хүчиндэх	62	35	27
	Хулгайлах	866	452	414
	○ Иргэдийн өмчийн	716	368	348
	○ Авто тээврийн хэрэгслийн	16	13	3
	○ Халаасны	98	53	45
	○ Бусад	36	18	18
	Дээрэмдэх	100	56	44
	Залилах	2 311	1 237	1 074
	Танхайрах	2	2	-
	ХАБТХАЖЭ[2]	171	89	82
	Бусад	1 013	698	315

Нийт бүртгэгдсэн 5344 гэмт хэргээс 2981 (55.8%) нь цагдаагийн I хэлтэст, 2363 (44.2%) нь цагдаагийн II хэлтэст гарч, өнгөрсөн оны мөн үеэс I хэлтэст 468 (18.6%), II хэлтэст 603 (34.3%) хэргээр тус тус өссөн сөрөг үзүүлэлттэй байна.


Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 276 (5.2%) нь согтуугаар, 287 (5.4%) нь бүлэглэн, 960 (18.0%) нь эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг байна.

ЗУРАГ 6. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, үйлдэгдсэн цаг, гарагаар, жил бүрийн 9 дүгээр сард



Энэ оны 9 дүгээр сарын байдлаар мягмар, лхагва, баасан гаригт хамгийн их буюу 2403 (55.0%) гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн хамгийн их үйлдэгдсэн нь лхагва гарагийн 06:00-14:00 цагийн хооронд байна. Дүүргийн хэмжээнд 2026 оны 9 дүгээр сарын байдлаар гэмт хэрэг хамгийн их үйлдэгдсэн газар болох гэр, орон сууцанд 2076 (38.8%) хэрэг, гудамж талбайд 1585 (29.7%) хэрэг, олон нийтийн газарт 900 (16.8%) хэрэг, бусад үйлдэгдсэн газар 783 (14.7%) тус тус бүртгэгдсэн байна

ЗУРАГ 7. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороогоор, жил бүрийн 9 дүгээр сард



Гэмт хэргийн гаралтыг хороо тус бүрээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34-р хороо 47 (51.6) хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байгаа бол бусад хороодод 1.1 хувиас 158.0 хувиар өссөн сөрөг үзүүлэлттэй байна. Дүүргийн долоодугаар хорооны нутаг дэвсгэрт 528 (61.5%) гэмт хэргийн бүртгэгдсэн нь хамгийн их байсан бол хамгийн бага нь 21, 27 28, 30, 34 дүгээр хороодод бүртгэгдсэн байна.

ХҮСНЭГТ 12. НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, хороо, төрлөөр, 2026 оны 9 дүгээр сард

Хороо	Нийт	Хүн амь	Хүнийг амиа хорлох нөхцөл	Хүний эрүүл мэндийн халдашгүй	Хүчин	Хулгай	Дээрэм	Залилан	Танхайрах	ХАБТХАЖЭ[2]	Бусад
	тоо										
Бүгд	**5 344**	**15**	**62**	**742**	**62**	**866**	**100**	**2 311**	**2**	**171**	**1 013**
I хороо	454	-	2	15	3	24	3	118	-	6	283
II хороо	434	2	1	21	2	50	5	298	1	9	45
III хороо	231	-	1	16	-	19	1	127	-	10	57
IV хороо	176	1	2	30	3	31	4	49	-	8	48
V хороо	175	-	4	31	3	54	3	44	-	13	23
VI хороо	195	-	2	30	-	40	2	82	-	12	27
VII хороо	528	-	1	32	-	19	3	444	-	7	22
VIII хороо	127	2	2	38	1	24	3	31	-	1	25
IX хороо	112	-	5	27	3	30	3	26	-	3	15
X хороо	94	1	2	12	3	16	3	30	-	3	24
XI хороо	270	-	2	31	5	37	3	141	-	11	40
XII хороо	108	-	2	22	2	16	4	36	-	3	23
XIII хороо	196	1	3	41	1	36	6	79	-	9	20
XIV хороо	177	-	-	38	1	48	5	47	-	7	31
XV хороо	89	-	-	16	1	17	2	34	-	2	17
XVI хороо	239	1	4	30	1	36	4	118	1	7	37
XVII хороо	176	1	-	39	5	28	4	61	-	5	33
XVIII хороо	149	-	3	25	2	21	3	53	-	7	35
XIX хороо	106	1	1	21	1	29	4	35	-	4	10
XX хороо	178	1	3	29	2	23	2	72	-	9	37
XXI хороо	54	-	-	6	2	10	2	23	-	2	9
XXII хороо	96	-	4	24	7	17	8	21	-	4	11
XXIII хороо	63	1	1	11	3	14	2	13	-	8	10
XXIV хороо	129	-	4	22	1	30	1	50	-	-	21
XXV хороо	76	-	3	15	3	15	-	22	-	3	15
XXVI хороо	144	1	1	20	1	36	1	53	-	5	26
XXVII хороо	50	-	1	8	-	10	-	25	-	-	6
XXVIII хороо	55	-	-	6	-	17	2	23	-	1	6
XXIX хороо	182	-	2	27	2	41	6	76	-	5	23
XXX хороо	26	-	1	4	-	8	-	8	-	1	4


Гэмт хэрэг

Хороо	Нийт	Хүн амь	Хүнийг амиа хорлох нөхцөл	Хүний эрүүл мэндийн халдашгүй	Хүчин	Хулгай	Дээрэм	Залилан	Танхайрах	ХАБТХАЖЭ[2]	Бусад
	тоо										
XXXI хороо	81	-	3	22	-	21	3	25	-	3	4
XXXII хороо	58	-	-	9	4	19	2	15	-	2	7
XXXIII хороо	72	2	-	14	-	17	5	23	-	1	10
XXXIV хороо	44	-	2	10	-	13	1	9	-	-	9

Бүртгэгдсэн зөрчил:

Дүүргийн нутаг дэвсгэрт энэ оны 9 дүгээр сарын байдлаар 28509 зөрчил илрүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 904 (3.1%) хэргээр өссөн, зөрчил гаргасан 28121 иргэн, хуулийн этгээдийг 1039.1 сая төгрөгөөр торгосон бол 388 хүнийг "Зөрчлийн тухай" хуулиар баривчилжээ. Нийт бүртгэдсэн зөрчлийн 40.1 хувь нь I хэлтэст, 59.9 хувь нь II хэлтэс тус тус бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 8. БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ, хэлтсээр, жил бүрийн 9 дүгээр сард




Нийт илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлт, илрүүлэлтийн хувийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад I хэлтэс 607 (5.5%) хэргээр, II хэлтэс 237 (1.4%) хэргээр буурсан байна. Нийт илрүүлсэн зөрчлийг нийслэлийн 9 дүүргийн хэлтсүүдтэй харьцуулахад Баянгол дүүргийн цагдаагийн II хэлтэс гуравдугаарт, I хэлтэс наймдугаарт эрэмбэлэгдэж байна.

Гэмт хэрэг

Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл:

Дүүргийн хэмжээнд 2026 оны 9 дүгээр сарын байдлаар 20199 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас 10260 (50.8%) нь гэмт хэргийн шинжтэй, 9939 (49.2%) нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл ирсэн байна.

ЗУРАГ 9. БҮРТГЭГДСЭН ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ, шалган шийдвэрлэсэн байдлаар, 2026 оны 9 дүгээр сард




Гэмт хэргийн шинжтэй 10260 гомдол мэдээллийн 9681 (94.4%) хэргийг шийдвэрлэснээс 3528 (36.4%) нь хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн, 5931 (61.3%) нь хэрэг нээхээс татгалзсан, 222 (2.3%) нь харъяаллын дагуу шилжүүлэн хэргийг шийдвэрлэсэн байна. Нийт шийдвэрлэсэн 9681 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг 5 хоногт 1345 (13.9%) хэргийг, 6-19 хоногт 8320 (85.9%) хэргийг, 20 дээш хоногт 16 (2.2%) тус тус шийдвэрлэн ажиллажээ. Нийт шалган шийдвэрлэгдсэн зөрчлийн шинжтэй 9939 гомдол мэдээллийн 9819 (98.8%) хэргийг шийдвэрлэснээс 4821 (49.1%) хэрэгт зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн, 4919 (50.1%) хэргийг нь зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан, 61 (0.6%) бүртгэлтийн хэрэг нээсэн, 18 (0.2%) хэргийг нь харьяаллын дагуу шилжүүлсэн байна.

Зам тээврийн осол, зөрчил:

2026 оны 9 дүгээр сарын байдлаар дүүргийн хэмжээнд нийт ослын шинжтэй 15476 дуудлага бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 978 (5.9%) дуудлагаар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 10. БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, дүүргээр, 2026 оны 9 дүгээр сард



Улаанбаатар хотод нийтдээ 10725 зам тээврийн осол бүртгэгдсний 2805 (26.2%) нь Баянзүрх, 2094 (19.5%) нь Хан-Уул, 1756 (16.4%) нь Сонгинохайрхан, 1697 (15.8%) нь Баянгол, 1533 (14.2%) нь Сүхбаатар, 822 (7.7%) нь Чингэлтэй, 12 (0.1%) нь Налайх, 6 (0.1%) нь Багануур дүүргүүдэд байна.

Бүртгэгдсэн ослыг дүүргийн хэмжээнд өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулан авч үзвэл 13.2 хувиар, эд материалын хохиролтой осол 13.8 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 13. БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, төрлөөр, жил бүрийн эхний 9 дүгээр сарын байдлаар


Үзүүлэлт	2024 I-IX	2025 I-IX	2026 I-IX	2026 I-IX / 2025 I-IX
	тоо			хувь
Нийт	**3 015**	**2 517**	**2 185**	**-13.2**
Эд материалын хохиролтой осол	2 703	2 261	1 949	-13.8
Хүн гэмтсэн осол	312	256	236	-7.8


Нийт зам тээврийн осол 2185 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 332 (13.2%) буурсан эерэг өөрчлөлттэй байна. Нийт бүртгэгдсэн зам тээврийн ослын 312 (89.2%) нь эд материалын хохиролтой осол, хүн гэмтсэн осол 20 (10.8%) тус тус буурсан байна. 2026 оны 9 дүгээр сарын байдлаар зам тээврийн ослын улмаас нийт 267 хүн бэртэж үүнээс хүн нас барсан 11 тохиолдол бүртгэгдсэн байна. Зам тээврийн ослын улмаас бэртсэн иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт хохирсон иргэн 11 (4.0%) буурсан эерэг өөрчлөлттэй байна.

ХҮСНЭГТ 14. ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС БЭРТСЭН ИРГЭД, төрлөөр, жил бүрийн эхний 9 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлт	2024 I-IX	2025 I-IX	2026 I-IX	2026 I-IX / 2025 I-IX
	Тоо			хувь
Нийт хохирсон иргэд	**341**	**278**	**267**	**-4.0**
Хүн гэмтсэн	339	275	256	-6.9
Хүн нас барсан	2	3	11	2.7**

ЗУРАГ 11. БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, хэлбэрээр, тээврийн хэрэгслийн төрлөөр, дүнд эзлэх хувь, 2026 оны эхний 9 дүгээр сарын байдлаар





Нийт гэмтсэн хүний 155 (58.1%) хувийг явган зорчигч, 30 (11.2%) хувийг зорчигч, 60 (22.5%) жолооч, 22 (8.2%) хувийг дугуйтай хүн эзэлж байна. Бүртгэгдсэн зам тээврийн ослын 1893 (86.6%) нь мөргөлдсөн, 166 (7.6%) нь явган хүн дайрсан, 86 (3.9%) нь үл хөдлөх зүйл мөргөсөн, 33 (1.9%) нь онхолдох болон бусад байна. Зам тээврийн ослыг тээврийн хэрэгслийн төрлөөр нь 1774 (81.1%) нь суудлын, 178 (8.1%) нь ачааны, 69 (3.2%) нь автобус, 15 (0.7%) микроавтобус, 54 (2.5%) нь мотоцикл, 28 (1.3%) нь унадаг дугуй, 67 (3.1%) нь бусад эзэлж байна. Энэ оны 9 дүгээр сарын байдлаар бүртгэгдсэн зам тээврийн ослын 3309 (71.0%) хэргийг даатгалд шилжүүлж, 1180 (25.3%) хэрэгт акт тавьж, 171 (3.7%) хэргийн өргөдлийг хүлээн авсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр:
Дүүргийн Цагдаагийн I, II хэлтсийн сарын мэдээ

ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Баянгол дүүргийн төсвийн нийт орлого 246 302.5 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 13.7 тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ.

Дүүргийн төсвийн нийт орлого 2026 оны эхний 9 сарын байдлаар 241 948.1 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 38961.3 (13.7%) тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ. Төсвийн нийт орлогын 96.5 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 3.5 хувийг татварын бус орлого тус тус эзэлж байна.

Татварын орлогын дүнд хувь хүний орлогын албан татварын шилжүүлэг хамгийн өндөр буюу 216 209.1(90.9%) тэрбум төгрөгийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 15. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2026 оны эхний 9 сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
	сая төгрөг		хувь
Нийт орлого	285 263.8	246 302.4	-13.7
1.Татварын орлого	279 394.3	237 796.3	-14.9
1.1 Орлогын албан татвар	258 235.1	216 209.1	-16.3
Хувь хүний орлогын албан татвар	258 235.1	216 209.1	-16.3
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал	208 580.1	160 852.3	-22.9
Үйл ажиллагааны орлого	3 020.0	3 480.3	15.2
Хөрөнгийн орлого	12 375.0	13 133.5	6.1
Хөрөнгө борлуулсны орлого	12 060.0	11 398.8	-5.5
Шууд бус орлого	22 200.0	27 344.1	23.2
1.2 Хөрөнгийн татвар	11 662.2	12 279.5	5.3
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	11 610	12 237.6	5.4
Бууны албан татвар	52.2	41.7	-20.1
Малд ногдуулах албан татвар	-	0.2	-
1.3 Бусад татвар, төлбөр, хураамж	9 497.0	9 307.8	-2
Бусад нийтлэг татвар, төлбөр, хураамж	4 655.0	3 966.5	-14.8
Улсын тэмдэгтийн хураамж	911.0	282.2	-69.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	-	56.5	-
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3 744.0	3 627.8	-3.1
Газрын төлбөр	4 842.0	5 337.6	10.2
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	-	3.7	-
2. Татварын бус орлого	5 869.5	8 506.1	44.9
2.1 Нийтлэг татварын бус орлого	5 078.5	7 691.6	51.5
Торгуулийн орлого	2 970.0	6 577.4	2.2**
Төсөвт байгууллагын өөрийн орлого /үндсэн/	2 093.8	1 085.2	-48.2
Төсөвт байгууллагын өөрийн орлого /туслах/	14.4	18.2	26.4
Бусад орлого	-	10.8	-
Нэр данс зөрүүтэй орлого	-	36.0	-
Нэр данс зөрүүтэй орлого	-	36.0	-
